



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/201/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: <a href="mailto:Bat-Undraa@audit.gov.mn">Bat-Undraa@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор : Б.Дагвасүрэн Утас:92038288 Цахим хаяг: <a href="mailto:dagvasurenb@audit.gov.mn">dagvasurenb@audit.gov.mn</a></p> <p>Аудитор Б.Жалбаа Утас: 89330330 Цахим хаяг: <a href="mailto:jalbaab@audit.gov.mn">jalbaab@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12

додл. од. 16 № 130д/55  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ГАЗРЫН ДАРГА Ө.БОЛД-Д

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013022923

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

СТ-1А

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/мян.төг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,179,181.09</b>	<b>979,588.11</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>700.30</b>	<b>308.77</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	308.77
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>700.30</b>	<b>0.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	498.93	0.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	201.37	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,178,480.79</b>	<b>979,279.34</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>225,483.66</b>	<b>67,850.30</b>
35110	Тусгай зориулалттай материал	214,028.36	64,136.05
35130	Эм боох материал	11,455.30	3,714.25
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>952,297.13</b>	<b>910,729.05</b>
35410	Бичиг хэргийн материал	3,572.83	4,610.04
35420	Аж ахуйн материал	528,004.64	364,429.60
35430	Сэлбэг хэрэгсэл	28,059.60	20,575.70
35440	Түлш, шатах тослох материал	4,707.92	50.00
35470	Бусад хангамжийн материал	387,952.14	521,063.71
35600	Мал амьтад	700.00	700.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,327,732.90</b>	<b>7,474,992.28</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>6,327,732.90</b>	<b>7,474,992.28</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>5,709,667.70</b>	<b>6,856,927.08</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,956,677.82	4,073,138.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	-527,835.97	-728,763.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	3,333,697.25	4,669,549.25
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,149,678.77	-1,531,074.62
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	567,781.76	619,791.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-477,753.52	-497,237.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,148.85	65,011.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	-60,198.88	-59,941.04
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	64,448.30	313,499.57
39212	Хуримтлагдсан элэгдэл	-61,619.13	-67,047.71
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>618,065.20</b>	<b>618,065.20</b>
39301	Програм хангамж	1,650.00	1,650.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,650.00	-1,650.00
39303	Бусад биет бус хөрөнгө	618,065.20	618,065.20
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>7,506,913.98</b>	<b>8,454,580.40</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,506,913.98</b>	<b>8,454,580.40</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>7,506,913.98</b>	<b>8,454,580.40</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,125,452.57	1,125,452.57
51101	Өмч: - төрийн	1,125,452.57	1,125,452.57
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>5,734,326.46</b>	<b>6,682,012.29</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	5,734,326.46	5,734,345.88
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	947,666.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	647,134.95	647,115.54
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>7,506,913.98</b>	<b>8,454,580.40</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/мян.төг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,543,426.72</b>	<b>5,014,574.92</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,436,409.73</b>	<b>1,936,538.76</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,436,409.73</b>	<b>1,936,538.76</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,436,409.73	1,936,503.76
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,436,409.73	1,936,503.76
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,107,016.99</b>	<b>3,078,036.16</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,716,090.50</b>	<b>2,679,854.10</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,716,090.50	2,679,854.10
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>390,926.49</b>	<b>398,182.06</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	29,384.06	172,003.91
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	0.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	150,788.96	116,620.15
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	202,239.78	105,558.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,513.70	4,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,339,671.90</b>	<b>4,066,908.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,339,671.90</b>	<b>4,066,908.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,229,013.61</b>	<b>4,060,173.31</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,026,547.70</b>	<b>2,155,588.60</b>
210101	Үндсэн цалин	1,336,418.10	1,263,141.30
210102	Нэмэгдэл	653,325.90	833,901.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,803.70	58,545.72
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>71,491.20</b>	<b>69,510.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	23,050.60	17,973.80
210202	Тэтгэмжийн даатгал	4,479.00	2,114.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,097.50	9,691.60
210204	Ажилгүйдлийн даатгал	524.30	422.90
210205	Эрүүл мэндийн даатгал	41,339.80	39,307.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>222,889.75</b>	<b>220,646.30</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,249.81	17,550.11
210302	Түлш, халаалт	196,231.16	195,704.85
210303	Цэвэр, бохир ус	11,408.78	7,391.34
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>65,347.77</b>	<b>91,680.47</b>
210401	Бичиг хэрэг	3,420.50	3,097.40
210402	Тээвэр, шатахуун	58,273.00	84,014.09
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,093.87	3,574.18
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	560.40	994.81
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>75,924.76</b>	<b>84,893.10</b>

**Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	790.26	4,253.10
210502	Хоол, хүнс	74,688.00	80,640.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	446.50	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>41,852.15</b>	<b>46,850.40</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,953.65	12,976.60
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,212.80	0.00
210604	Урсгал засвар	35,685.70	33,873.80
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>80,298.20</b>	<b>96,522.20</b>
210702	Дотоод албан томилолт	80,298.20	96,522.20
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,320.75</b>	<b>13,142.60</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	6,964.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806.40	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,504.80	1,504.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,435.50	435.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	868.80	356.40
210807	Газрын төлбөр	1,705.25	3,881.90
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>636,341.33</b>	<b>1,281,339.14</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	191,117.47	575,085.34
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,881.60	9,450.12
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	442,342.26	696,803.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>110,658.29</b>	<b>6,735.20</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>104,600.00</b>	<b>6,735.20</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	104,600.00	6,735.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.04	0.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,058.25</b>	<b>0.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,058.25	0.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,203,754.82</b>	<b>947,666.41</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,203,754.82</b>	<b>947,666.41</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	507,387.37	69,867.85	2,257,553.26	2,834,808.47
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	507,387.37	69,867.85	2,257,553.26	2,834,808.47
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	5,199.85	5,199.85
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,125,452.57	647,134.95	5,734,326.46	7,506,913.98
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,125,452.57	647,134.95	5,734,326.46	7,506,913.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	19.42	19.42
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	1,125,452.57	647,134.95	5,734,345.88	7,506,933.40
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-19.42	0.00	-19.42
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	947,666.41	947,666.41
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,125,452.57	647,115.54	6,682,012.29	8,454,580.40

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

СТ-2А

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/мян.төг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>3,128,466.63</b>	<b>3,078,071.16</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,128,466.63</b>	<b>3,078,036.16</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,716,090.50</b>	<b>2,679,854.10</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,716,090.50	2,679,854.10
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>412,376.13</b>	<b>398,182.06</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	29,384.06	172,003.91
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	150,788.96	116,620.15
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	202,239.78	105,558.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,963.33	4,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3,085,224.89</b>	<b>2,972,190.26</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,085,224.89</b>	<b>2,972,190.26</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,974,566.60</b>	<b>2,965,146.29</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,026,547.70</b>	<b>2,154,956.20</b>

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	1,272,163.70	1,263,141.30
210102	Нэмэгдэл	713,942.50	833,901.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,441.50	57,913.32
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>71,491.20</b>	<b>69,510.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,907.70	17,973.80
210202	Тэтгэмжийн даатгал	2,621.90	2,114.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,097.50	9,691.60
210204	Ажилгүйдлийн даатгал	524.30	422.90
210205	Эрүүл мэндийн даатгал	41,339.80	39,307.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>240,226.00</b>	<b>231,426.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,249.81	17,550.11
210302	Түлш, халаалт	213,567.41	206,484.55
210303	Цэвэр, бохир ус	11,408.78	7,391.34
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>72,239.97</b>	<b>51,283.40</b>
210401	Бичиг хэрэг	3,587.00	4,348.11
210402	Тээвэр, шатахуун	62,974.37	42,605.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,118.20	3,335.18
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	560.40	994.81
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>76,224.76</b>	<b>81,430.30</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	790.26	790.30
210502	Хоол, хүнс	74,688.00	80,640.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	746.50	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>194,934.90</b>	<b>47,471.80</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	142,036.40	13,215.60
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,712.80	0.00
210604	Урсгал засвар	42,185.70	34,256.20
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>80,298.20</b>	<b>96,282.20</b>
210702	Дотоод албан томилолт	80,298.20	96,282.20
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,421.50</b>	<b>13,240.30</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	7,129.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806.40	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,504.80	1,504.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,435.50	435.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	868.80	356.40
210807	Газрын төлбөр	2,806.00	3,814.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>203,182.37</b>	<b>219,545.59</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,300.77	210,155.39
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,881.60	9,390.20
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>110,658.29</b>	<b>7,043.97</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>104,600.00</b>	<b>6,735.20</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	104,600.00	6,735.20
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,058.25</b>	<b>0.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,058.25	0.00

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	308.77
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	308.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	43,241.74	105,880.90
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	43,241.74	105,880.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	43,241.74	105,880.90
2200	Дотоод эх үүсвэрээр	43,241.74	105,880.90
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	43,241.74	105,880.90
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-43,241.74	-105,880.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,679,854.10	2,679,854.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,679,854.10	2,679,854.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,673,118.90	2,673,118.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,154,956.20	2,154,956.20
210101	Үндсэн цалин	1,263,141.30	1,263,141.30
210102	Нэмэгдэл	836,880.90	833,901.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,934.00	57,913.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,087.60	69,510.50
210201	Тэтгэврийн даатгал	17,973.80	17,973.80
210202	Тэтгэмжийн даатгал	2,114.60	2,114.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,691.60	9,691.60
210204	Ажилгүйдлийн даатгал	422.90	422.90
210205	Эрүүл мэндийн даатгал	39,307.60	39,307.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	231,426.00	231,426.00
210301	Гэрэл, цахилгаан	12,000.00	17,550.11
210302	Түлш, халаалт	211,401.10	206,484.55
210303	Цэвэр, бохир ус	8,024.90	7,391.34
2104	Хангамж, бараа материалын зардал	34,288.40	34,288.40
210401	Бичиг хэрэг	3,587.00	4,313.11
210402	Тээвэр, шатахуун	25,522.80	25,645.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,618.20	3,335.18
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,560.40	994.81
2105	Нормативт зардал	81,430.30	81,430.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	790.30	790.30
210502	Хоол, хүнс	80,640.00	80,640.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76,902.80	76,902.80
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,367.60	22,367.60

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	54,535.20	54,535.20
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,974.20</b>	<b>1,974.20</b>
210702	Дотоод албан томилолт	1,974.20	1,974.20
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,110.70</b>	<b>13,240.30</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	7,129.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,504.80	1,504.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	435.50	435.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	356.40	356.40
210807	Газрын төлбөр	3,814.00	3,814.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,129.60</b>	<b>9,390.20</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,129.60	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,390.20	9,390.20
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>6,735.20</b>	<b>6,735.20</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,735.20	6,735.20
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,679,854.10</b>	<b>2,679,854.10</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,679,854.10</b>	<b>2,679,854.10</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,679,854.10	2,679,854.10

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

НТ-2

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ мян.төг /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	331,908.29
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	331,908.29
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	331,908.29
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,995.00
210401	Бичиг хэрэг	35.00
210402	Тээвэр, шатахуун	16,960.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	94,308.00
210702	Дотоод албан томилолт	94,308.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	220.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	220,605.29
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	66,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	66,000.00
221001	Их засвар	48,000.00
222001	Тоног төхөөрөмж	18,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	398.18
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	398,182.06
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	172,003.91
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	116,620.15
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	105,558.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,000.00
--------	--	----------

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, Ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Онцгой байдлын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 27/44 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Онцгой байдлын газар нь “Онцгой байдлын албаны техник, багаж, тоног төхөөрөмж, хувцас хэрэгслийн чанар ашиглалтыг сайжруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэд технологийг нэвтрүүлж төрийн үйл ажиллагааг цахимжуулах” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж тус байгууллагад байхгүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 5,029,936.5 мянган төгрөгийн 1 хувь буюу 50,299.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 35,209.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	700.30	308.80	-391.50
Бараа материал	1,178,480.80	979,279.30	-199,201.50
Үндсэн хөрөнгө	6,327,732.90	7,474,992.30	1,147,259.40
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,506,914.00</b>	<b>8,454,580.40</b>	<b>947,666.40</b>
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,506,914.00	8,454,580.40	947,666.40
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>7,506,914.00</b>	<b>8,454,580.40</b>	<b>947,666.40</b>

Авлага дансны үлдэгдэл 391.5 мянган төгрөг болж буурсан нь өмнөх оны авлагыг бүрэн багадуулж тайлант онд шинээр 308.8 мянган төгрөгийн санхүүжилтийн авлага бүртгэгдсэнтэй холбоотой байна. Энэ нь орон нутагт төвлөрүүлэх орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой бий болсон байна.

Бараа материал дансны үлдэгдэл 979,279.3 мянган төгрөг болж буурсан өмнөх оны үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна. Тухайлбал өмнөх онд ковид-19 цар тахалтай холбоотой нөөцөлсөн байсан материалын зарцуулсан нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,474,992.3 мянган төгрөг болж өссөн нь элэгдлийн зардал болон дараах хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой байна.

- ✓ ОБЕГ болон бусад онцгой байдлын анги байгууллагаас 1,738,182.2 мянган төгрөгийн батлан хамгаалахын зориулалттай тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгсэл шилжүүлэн авсан
- ✓ Эрх бүхий байгууллагын шийдвэрээр 57,880.9 мянган төгрөгийн барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авсан
- ✓ Эрх бүхий байгууллагын шийдвэрээр 89,826.5 мянган төгрөгийн хөрөнгө акталсан зэрэг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,454,580.4 мянган төгрөг болж өссөн нь нь хуримтлагдсан үр дүн 947,666.4 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Дээд шатны төсөв захирагч тус байгууллагын 2021 оны төсвийн зарлагыг 2,769,689.2 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,769,689.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр санал хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн төслийг хянаад 2021 оны зарлагыг 2,679,431.2 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,679,854.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,679,854.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 2,679,854.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 398,182.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд:

- Ковид-19 цар тахалтай холбоотой хандив тусламжийн орлого 172,003.9 мянга,
- ГХУСАЗСЗ-ийн зардалд Аймгийн ИТХ-аас 4,000.0 мянга,
- Аймгийн ЗДНХ-өөс 106,561.9 мянга
- Дээд шатны төсөв захирагчаас олгосон 105,588.0 мянга,
- БСУГ-аас ариутгал, халдваргүйжүүлэлтэд зориулан олгосон 4,000.0 мянга,
- Өмнөх оны үлдэгдлээс 6,028.3 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Ковид-19 цар тахалтай холбоотой цугласан хандивын зарцуулалтыг аудитаар авч үзлээ. 2021 онд нийт 172,003.9 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна. Аймгийн онцгой комиссын хуралдааны шийдвэрээр ковид-19 цар тахалтай холбоотой зардлуудад 131,517.8 мянган төгрөгийг зарцуулж, 40,486.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Аудитаар хандивын зарцуулалттай холбоотой зөрчил илрээгүй бөгөөд аймгийн онцгой комиссын үйл ажиллагаанд зориулан худалдан авсан тоног төхөөрөмжийг данс бүртгэлд бүртгэсэн нь тодорхой бус байгаад зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

### **3.8 Аудитын гол асуудал**

Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

### **3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ**

Байгууллагын үйл ажиллагааны зардал болох тээвэр шатахуун, хүнсний материалыг нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байдлыг санхүүгийн аудитаар шалгахад материаллаг алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 166 мэдээллээс 158 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулж, 22 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 7 мэдээллийг огт байршуулаагүй, 2 мэдээллийг хугацаа болоогүй байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 8169 хувьтай байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд НББ-ийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн тайлагнаж Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй бөгөөд албан хаагчдад цалин илүү олгосонтой холбоотой 26,028.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй, шилэн дансны мэдээллийг хангалтгүй мэдээлсэн зэрэгтэй холбоотой 17,889.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн бөгөөд хэрэгжилт бүрэн хангагдсан байна.

#### **3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

### **4. Аудитын илрүүлэлт**

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар 54,782.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

#### **4.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар барилгын их засварын зардлыг буруу тайлагнасан 48,000.0 мянган төгрөгийн , худалдан авсан хөрөнгийг данс

бүртгэлд тусгаагүй 2,070.5 мянган төгрөгийн, албан хаагчдад олгосон цалингийн тооцоолол буруу хийсэн 319.5 мянган төгрөгийн нийт 50,390.0 мянган төгрөгийн алдааг аудитаар залруулсан

#### 4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй байна.

#### 4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй байна

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. **Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

#### 1.1. Илрүүлэлт:

Томилолтын хуудсанд ирсэн явсан хугацаа бичигдээгүй, тамга тэмдгээр баталгаажаагүй, томилолтыг хуулбар хувиар олгосон 792.0 мянган төгрөгийн зөрчил байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, болон санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

Томилолтын хуудасны иж бүрдлийг хангаж, хүчин төгөлдөр баримтаар ажил гүйлгээг данс бүртгэлд тусгах

### 2. **Дотоод хяналт хариуцлагатай холбоотой**

#### 2.1. Илрүүлэлт:

НҮБ-ийн төслөөр хэрэгжих гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөрийн зардлыг зарцуулснаар тайлагнасан 3,600.0 мянган төгрөгийн зөрчил байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

#### 2.2. Өгсөн зөвлөмж:

НҮБ-ийн төслөөр хэрэгжих ажлын зардлын тайлан гаргаж ирүүлэх

### 3. **Дотоод хяналт хариуцлагатай холбоотой**

Ковид-19 цар тахалтай холбоотой цугласан хандивын мөнгөөр бусад байгууллагад худалдан авсан хөрөнгийн бүртгэл хөтлөлт тодорхой бус байна. Энэ нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 04 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Онцгой байдлын газар	6	54.8	3	50.4					3	4.4

/сая төгрөгөөр/

**БОЛОВСРУУЛСАН:**

АУДИТОР

Б.ЖАЛБАА

**ХЯНАСАН:**

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АХЛАХ АУДИТОР

Б.ДАГВАСҮРЭН



2022.02.18